

ОРОН НУТАГ ДАХ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ БОЛОМЖ

Д.Сувдаа*, Г. Эрдэнэцогт**

Хураангуй: Орон нутгийн хөгжлийг дэмжих бодлогууд амжилттай хэрэгжих гол хөшүүргийн нэг нь санхүүжилтийн асуудал юм. Сүүлийн жилүүдэд МУ-ын Засгийн Газар болон ОУ-ын байгууллагуудаас сум, орон нутгийн хөгжил болоод ЖДҮ эрхлэгчдийг дэмжих зорилгоор тусгай зориулалттай сангуудаар дамжуулан харьцангуй сайн нөхцөлтэй төрөл бүрийн хөнгөлөлттэй зээл, тусламж, санхүүжилт олгож байгаа ч хэрэгжилт, үр дүн нь төдийлөн хангалтгүй байна. Иймд, бидний судалгааны зорилго нь Орон нутаг дахь хөгжлийн болон ЖДҮ-ийг дэмжих зориулалт бүхий тусгай зориулалттай сангийн хөрөнгө болон зээлийн зарцуулалт, тулгамдаж буй асуудлууд, түүний үр ашгийг хэрхэн нэмэгдүүлэх боломж ямар байгааг тодорхойлох явдал юм. Судалгаандаа бид орон нутаг хөгжүүлэх сан болон Сум хөгжүүлэх сангуудын хөрөнгийн зарцуулалт, үр ашгийг сайжруулах боломжийн талаар судалж, үнэлэлт дүгнэлт өгөхийг зорьсон болно.

Түлхүүр үгс: Орон нутаг хөгжүүлэх сан, ЖДҮ, тусгай зориулалттай сан, хөрөнгийн зарцуулалт, үр ашиг

Abstract: Funding is one of key incentives for successful implementation of local development policies. In recent years, the Government of Mongolia and international organizations provide various types of soft loans, loans and grants, with relatively good conditions through specialized funds to support local development and SMEs. However, implementation and results are not enough. Therefore, our research goal is to identify the potential for funds for the development of the local community and SMEs, as well as how to increase their spending, challenges and benefits. In our research, we studied audit reports done at local development funding implementation results, the usage and to study and evaluate the possibility to improve the benefits.

Key words: Local development fund, SME, special fund, capital expenditure, efficiency

* МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail) d.suvdaa@num.edu.mn

** МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail) erdenetsogt@mandakh.mn

Удиртгал

Сүүлийн жилүүдэд, орон нутгийн хөгжил гэж юуг ойлгох, өрсөлдөх давуу талуудаа хэрхэн тодорхойлох, орон нутгийн хөгжлийг даяарчлалтай хэрхэн үр дүнтэй уялдуулах вэ зэрэг асуудлууд нь эрдэмтэн судлаачдын анхаарлыг ихэд татаж байна. Энэхүү бодлогын уялдааг хангах цорын ганц боломж нь үйлдвэрлэлийн салбар болон компаниудын үр ашигтай хамтын ажиллагаа буюу кластерт суурилсан бодлого болж байна. (Enright, 2000)

Орон нутгийг жигд хөгжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтыг аймаг, орон нутгийн хөгжлийн бодит төвшинд тулгуурлан оновчтой төлөвлөхөд ашиглах хөгжлийн индекс тооцох аргачлалыг Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 88 дугаар тогтоолоор баталж, хөгжлийн үзүүлэлтийг 9 бүлэг, 65 үзүүлэлтээр тооцож, (ОНХИТА, 2010) орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг тооцоход ашиглаж байсан боловч, улс орны төсвийн хүндрэлтэй холбоотойгоор одоогоор хэрэглээгүй байна.

Иймд бидний судалгааны зорилго нь орон нутгийн хөгжлийн индексийг оновчтой тодорхойлох аргуудыг судлах, орон нутгийн хөгжлийн гарцыг илэрхийлэх ба мөн орон нутаг дахь хөгжлийн болон ЖДҮ-ийг дэмжих зориулалт бүхий орон нутгийн болон улсын төсвийн хөрөнгө оруулалт, тусгай зориулалттай сан, хөнгөлөлттэй зээлийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлууд, түүний үр ашгийг хэрхэн нэмэгдүүлэх боломж байгааг тодорхойлох явдал юм. Үүний тулд бид орон нутгийн тусгай зориулалттай сангуудын хэрэгжилт, үр ашигт хийгдсэн аймгуудын аудитын газрын тайлангууд, хөнгөлөлттэй зээлийн зориулалт, нөхцөл, гүйцэтгэлээс гадна, орон нутаг хөгжүүлэх сангийн зарцуулалтыг судалж, зөрчлийг арилгах, үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг судалж санал, зөвлөмжийг боловсруулсан болно.

Орон нутгийн санхүү

Тогтвортой хөгжил гэдгийг (Dagsupta.P, 2007) одоогийн болон ирээдүй үеийнхний амьдралын дундаж төвшин ямар ч үед буурахгүй байхыг хэлнэ гэж тодорхойлсон бол, хүртээмжтэй өсөлтийг (Ali.I, Measuring Inclusive Growth, 2007) нийгмийн баялгаас тэгш хүртэх байдал хэмээн тодорхойлсон.

Орон нутгийн хөгжил нь тодорхой хэсэг бүс нутаг, засаг захиргааны нутаг дэвсгэрийн бодит боломжийг авч үздэг. Орон нутгийн хөгжилд эдийн засгийн болон эдийн засгийн бус олон хүчин зүйлс нөлөөлөх ба орон нутгийн эдийн засгийг дотоод хэрэглээний болон экспортын гэж хоёр хувааж авч үздэг. (Isard.W, 1965) Үүгээр экспорт нь тухай бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн

суурь болж, ажил эрхлэлтийг дэмжин, хөгжлийн онцлог шинж чанарыг харуулж чаддаг. Экспортын үйл ажиллагаа эрхэлж байгаа эдийн засгийн салбарууд болон компаниуд нь дотоод зах зээл дээр бүтээгдэхүүнээ борлуулдаг болон үйл ажиллагааны хамаарал бүхий эдийн засгийн салбаруудад хүчтэй нөлөөлөл үзүүлж, хамтдаа хөгжих үндсийг бүрдүүлдэг. (Alicja.S, 2009).

Монгол улс сүүлийн жилүүдэд ДНБ-ийхээ 20 гаруй хувийг уул уурхайгаас бүрдүүлж байгаа. ДНБ-ий бүтцийг бүсээр авч үзвэл дийлэнх хувь нь Улаанбаатар хотод ногдож, үйлдвэрлэл явагдаж байгаа бүс нутгийн эдийн засагт төдийлөн хувь нэмрээ оруулахгүй байна. Тухайлбал, 2005-2010 оны дунджаар Улаанбаатар 59.3 хувь, хангайн бүс 19.5, төвийн бүс 10.1 хувь, баруун бүс 6.7 хувь, зүүн бүс 4.3 хувийг эзэлж байсан бол 2011-2018 онуудад дунджаар Улаанбаатар хотын эзлэх хувь 6.2 пунктээр, зүүн бүсийнх 1 пунктээр өсөж, бусад бүсийнх буурсан хандлагатай байна.

Бүсүүдийн ДНБ-ий салбаруудын бүтцийг авч үзвэл, 2010 онд баруун бүсийн ДНБ-ий 45 гаруй хувийг ХАА-н салбар бүрдүүлж байсан бол үйлдвэрлэл, үйлчилгээний салбар өргөжсөнөөр 2018 онд ХАА-н салбарын эзлэх хувь 40.4 болсон. Зүүн бүсийн хувьд 2010 онд ХАА-н болон үйлдвэрлэлийн салбарын эзлэх хувь тэнцүү 39 хувь байсан бол 2018 онд үйлдвэрлэлийн салбар 52.7 хувь болж нэмэгдсэн байна. Хангайн бүсийн 2010-2018 оны салбаруудын бүтцэд томоохон өөрчлөлт гараагүй байна. Төвийн бүсийн хувьд үйлдвэрлэлийн салбарын эзлэх хувь өсөж 44 хувьд хүрсэн нь улсын хэмжээнд үйлдвэрлэлийн салбар дийлэнх хувийг эзлэхэд багагүй нөлөө үзүүлсэн. (Хавсралт №1: ДНБ, салбараар, бүс нутгаар)

Орон нутгийн төсвийн орлогыг авч үзвэл нийт орлогын сүүлийн жилүүдэд дунджаар 45 орчим хувийг Улаанбаатар хот эзлэж байна. Зүүн бүсийн хувьд 2010 оны байдлаар хамгийн бага буюу 5 хувийг эзлэж байсан бол 2018 онд 2.6 орчим пунктээр нэмэгдсэн байгаа бөгөөд бусад бүсүүд харьцангуй ижил төвшинд буюу Хангайн бүс 2007 он гэхэд нийт төсвийн орлогын 28 хувийг эзлэж байсан бол 2018 оны байдлаар энэ үзүүлэлт буурч 18 хувьд хүрчээ. (Хавсралт №2: ОНТ-ийн орлого, бүсээр, улсын дүнд эзлэх хувиар)

Орон нутгийн төсвийн тэнцэл 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралын үеэр -821.5 сая төгрөгийн алдагдалтай, 2009-2013 онд ашигтай гарч байсан бол 2014 оноос эхлээд алдагдалтай гарах болсон байна. Дээрх алдагдлыг бүсээр авч үзвэл Төвийн бүсийн алдагдлын хэмжээ -25 тэрбум төгрөг хүрсэн ч, 2018 онд 33.7 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Харин алдагдлын хэмжээ хамгийн их өссөн нь Баруун бүс 2014 онд -1.5 тэрбум төгрөг байсан бол 2018 -13.6 тэрбум төгрөгт хүрсэн. (Хавсралт №3: ОНТ-ийн тэнцэл, бүсээр, улсын дүнд эзлэх хувиар)

Орон нутаг дах зээлийн санхүүжилтийн өнөөгийн байдал

Монгол улсын засгийн газар сүүлийн 20 орчим жилийн хугацаанд орон нутаг, бүсийн хөгжилд чиглэсэн *Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (2001)*, *Бүсийн хөгжлийн дунд хугацааны стратеги (2003)*, *Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого (2008)*, *Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл (2009)* зэрэг олон арван бодлого, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх болсон. Гэвч өнөөг хүртэл хот хөдөөгийн хөгжлийн ялгаа байсаар байгааг нийслэл хотоос алслагдсан бүс, аймаг, сумдын хоорондох нийгэм, эдийн засгийн тэнцвэрт байдал алдагдсанаас харж болох юм. Энэ нь засгийн газраас хэрэгжүүлж буй макро эдийн засаг, санхүүгийн бодлого нь ядуурлыг бууруулах, өсөлтийг дэмжих хүрээнд хязгаарлагдаж байгаа нь эдийн засгийн өсөлтийг дэмжих бус харин тогтвортой байдлыг хангахад илүү анхаарсан болохыг зарим судлаачид анхааруулсан байна. Манай улсад хэрэгжүүлж буй хөдөө, орон нутаг хөгжүүлэх ихэнх төсөл, хөтөлбөр, бодлого нь дэд бүтэц, орон нутгийн бие даасан байдал, иргэдийн амьжиргааны төвшинг дээшлүүлэх гэсэн үндсэн 3 асуудлын хүрээнд яригдаж байгаа ч эдгээрийг шийдвэрлэх гол хөшүүрэг нь санхүүжилтийн асуудал юм.

Манай улс дээрх асуудлыг шийдэх зорилгоор 1994 онд Монгол улсын Засгийн газар Дэлхийн Банктай хамтран “Ядуурлыг бууруулах төсөл”-ийг хэрэгжүүлж эхэлсэн ба үүнийг өнөөгийн ЖДҮ-ийг хөгжүүлэх төслийн эхлэл хэмээн үздэг. Мөн орон нутгийн хөгжил, бие даасан байдлыг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газар болон олон улсын байгууллагуудаас ОНХС, ХЭДС, ЖДҮДС, БХС, СХС зэрэг тусгай зориулалттай сангаас гадна Японы Жайка, Швейцарийн ВРН, Германы KFW, ЕСБХБ-ны “Монголын тогтвортой эрчин хүчний санхүүжилт” төсөл, АХБ-ны “ХАА, хөдөөгийн хөгжил” төсөл, ОУСК-ийн “ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдийн оролцоотой бизнесийг дэмжих” хөнгөлөлттэй зээл, АНУОУХА-ын “Баталгаа гаргах хөтөлбөр” зэрэг хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр, тусламжаар дамжуулан санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаа ба дийлэнх төслийн зориулалт нь орон нутаг дахь ЖДҮ-ийг дэмжихэд чиглэгдсэн байна.

Хүснэгт 1. ЖДҮ-ийг дэмжих зээлүүдийн нөхцөл, хураамж, шимтгэл

Санхүүжүүлэгч байгууллага	ЖДҮ-ийг дэмжих буй хөнгөлөлттэй, төслийн зээл	Хүү	Хугацаа	Дээд хэмжээ	Шимтгэл	Хураамж
		Хувь	Жил	Сая төг	Хувь	Төгрөг
СХС	Орон нутаг дахь ЖДҮ	3	3	15 сая	0	0

АХ-ийн банк	Ажлын байр нэмэгдүүлэх төсөл	10	2	30 сая	0.5	5000
ЖДҮХС	ЖДҮ-ийг дэмжих төслийн зээл	7	5	200 сая	0	0-20000
Японы ЭГ	Экспортыг дэмжих төслийн зээл	4	24/12/06	Годорхойгүй	0.25	0
Жайка	ЖДҮ-ийг хөгжүүлэх төсөл	8	8	400 сая	0	20000
ХБНГУ- KFW	Хөнгөлөлттэй төслийн зээл	7.25	5	250,0 евро	0.5	10000
Хөгжлийн банк	ЖДҮ-ийн хөгжлийн зээл	9	19/03/05	Годорхойгүй	0	10000
ХЭДС	ЖДҮ-ийг дэмжих төслийн зээл	10.2	2	10 сая	1	5000
IFAD	ХААХ төслийн зээл	8	3	10 сая	1	5000
Банкуудын бизнесийн зээлийн дундаж		28.4	2.3333	141 сая	0.7	11333

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол


Эдгээр зээлүүдэд тавигдаж буй нийтлэг шаардлагуудын хувьд зээлийн барьцаа хангасан үл хөдлөх хөрөнгөтэй байх, батлан даалттай зээлдэгчийн батлан даалт нь шаардлага хангасан байх, үйлдвэрлэл үйлчилгээ явуулахад шаардагдах мэргэжлийн боловсон хүчин, ажлын байрны нөхцөлийг бүрдүүлсэн байх, хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлгүй, бизнесээ нэгээс дээш жил эрхэлсэн байх, барьцаа хөрөнгөтэй байх зэрэг шалгуур тавьж байгаа нь орон нутгийн ЖДҮ эрхлэгчдэд хүндрэл учруулсаар байна.

Монголбанкнаас хийсэн түүвэр судалгаанаас (Монголбанк, 2018.10) үзэхэд тус судалгаанд хамрагдсан нийт 1864 ЖДҮ эрхлэгчдийн 760 нь буюу 41% нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэх болон бизнесээ өргөтгөх зорилгоор тодорхой хэмжээний гадаад санхүүжилт авч чадсан байна. Эдгээрийг салбарын ангиллаар авч үзвэл тухайн жилд үйлдвэрлэл эрхлэгчдийн 48% нь, ХАА-н салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн 45% нь санхүүжилт авсан ба ХАА болон үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд санхүүжилтийн хэрэгцээ худалдаа, үйлчилгээний салбарын ЖДҮ эрхлэгчдтэй харьцуулахад өндөр байдаг гэсэн үр дүн гарсан байна.

Хүснэгт 1-д дурдсанчлан ЖДҮ-ийг дэмжих хэд хэдэн төрлийн зээл,

санхүүжилт байдаг ч дээрх судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн авсан нийт зээлийн 78 хувийг арилжааны банкнаас авч, 12 хувийг л бусад хөнгөлөлттэй зээлийн нөхцөлөөр авсан байна.


Зураг 1. ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилтийн эх үүсвэр (хувиар)



*Эх сурвалж: Монголбанк, Жижиг Дунд
Үйлдвэрлэлийн тцүвэр судалгаа, 2017-2018*

Гэвч өмнөх жилтэй харьцуулахад банкны зээлийн санхүүжилтийн хэмжээ 3 пунктээр буурч, харин хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт 6 пунктээр нэмэгдсэн үзүүлэлт харагдаж байгаа юм. Энэ нь банкны байгууллагаас тавьдаг шалгуур үзүүлэлттэй холбоотой гэж үзэж болохоор байна. Санхүүжилт авч чадаагүй ЖДҮ эрхлэгчдийн 21 хувь нь зээлийн хатуу нөхцөлөөс болж татгалзсан, 9% нь зээлийн нөхцөлийг хангаж чадаагүй байна.

Зураг 2. Зээлийн хатуу нөхцөлд тооцогдох хүчин зүйлс (хувиар)



*Эх сурвалж: Монголбанк, Жижиг Дунд
Үйлдвэрлэлийн тцүвэр судалгаа, 2017-2018*

Энд хатуу нөхцөл гэдэгт зээлийн хүү өндөр (Арилжааны банкуудын бизнесийн зээлийн дундаж хүү 28.8%) гэх шалтгаан хамгийн их бол, үүнээс гадна ЖДҮ эрхлэгчид эргэлтийн хөрөнгө (нийт санхүүжилтийн 57%) болон машин, тоног төхөөрөмжийн (нийт санхүүжилтийн 17%) хөрөнгө оруулалтад санхүүжилтээ зарцуулдаг учир зээлийн хугацаа богино гэх шалтгаан багагүй хувийг эзэлж байна. Мөн арилжааны банкуудад барьцаанд тавихаар санал болгосон хөрөнгийн үнэлгээ зах зээлийн үнээс харьцангуй багаар тооцогддог гэх гомдол ЖДҮ эрхлэгчдээс гардаг байна.

Орон нутагт хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол Улсын Төсвийн тухай хууль нь 2011 онд шинэчлэгдэн батлагдсан ч 2013 оноос эхлэн бүрэн хэрэгжиж эхэлсэн ба анх батлагдсан цагаас хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд 33 удаагийн шинэчлэл хийгдсэн (2018.11.02-ны өөрчлөлт) ба сүүлийн өөрчлөлтөөр “Хүний хөгжлийн сангийн төсөв”-ийг хассан. Хуульд тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий Орон нутгийн хөгжлийн сантай байх, мөн тус сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулсны үндсэн дээр аймаг нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орлогын шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сумын орон нутгийн хөгжлийн санд тус хуулийн 59.3-т заасан итгэлцүүрийг үндэслэн тооцно гэж заасан.

Эх үүсвэрийн хувьд

- Импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 25 хувь;
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс орсон орлогын 5 хувь;
- Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив;
- Доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлэх хөрөнгөөс бүрдүүлэхээр заасан.

Уг хууль батлагдсанаас хойш орон нутаг дахь хөрөнгө оруулалтыг бүсээр авч үзвэл нийт 7 жилийн хугацаанд 2.6 их наяд төгрөг байна. Үүнд, 2014 онд нийт улсын хэмжээнд хамгийн их хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Үүнээс Улаанбаатар хотын хөрөнгө оруулалт 42.4%, Төвийн бүс 26.6 хувийг эзэлж байгаа нь хамгийн их хөрөнгө оруулалттай байсан бүсүүдэд тооцогдож байна. Мөн зээлийн хөрөнгө оруулалт нь өмнөх жилийн төлөлтөөс шалтгаалдаг тул 2013-2015 онуудад эргэн төлөлт сайн байсан гэж дүгнэж болохоор байна. Мөн орон нутагт хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө оруулалт хийхэд дараах зүйлсийг

хориглосон байдаг. Үүнд,

Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ (УИХ, Монгол улсын төсвийн тухай хууль, шинэчилсэн найруулга, 58.1.1-58.1.21, 2018)


Улс төрийн нам, төрийн бус байгууллагын зарлага

Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал

Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа (УИХ, Монгол улсын Захиргааны Ерөнхий хууль 9-р бүлэг, 92.1, 2015)

- Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ

Зураг 3. Орон нутаг дах хөрөнгө оруулалтын төрөл, хэмжээ (сая төгрөгөөр)



Эх сурвалж: Монгол Улсын Сангийн яам, 2017

Орон нутаг дах хөрөнгө оруулалтын санхүүжилтийг төрлөөр нь авч үзэхэд нийт 14.4 тэрбум төгрөг, гэрээний нийт дүн 826.8 төгрөг санхүүжүүлсэн байна. Мөн нийт 1165 хөрөнгө оруулалтыг санхүүжүүлснээс бусад ангилалд багтсан санхүүжилт 31.7%-ийг эзэлж байна. Бусад төсөлд санхүүжүүлсэн хөтөлбөрийн нэг хөтөлбөрт дунджаар 42.2 сая төгрөг байсан бол нийт санхүүжилтийн нэг хөтөлбөрт санхүүжүүлсэн дундаж нь 35.2 сая төгрөг байна. Эндээс дүгнэхэд бусад категори дахь төсөл хөтөлбөр нь нийт хөтөлбөрийн ажлуудын 20%-г эзэлж байгаа боловч нийт санхүүжилтийн 32%-г эзэлж байгаа нь бусад хөтөлбөрүүд илүү үнийн дүнтэй төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлсэнтэй холбоотой. Нөгөө талаар зөвхөн төсөл хөтөлбөрүүдээр зогсохгүй нийт санхүүжилт авсан төслүүдийн хэрэгжилтийн хангах ерөнхий нэрэн доор давхардуулж олгосон

байж болзошгүй нь харагдаж байна.

“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам” –ын 5.1-д “Сангийн үйл ажиллагаа нийтэд ил тод, нээлттэй байна. Сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад тухайн сумын иргэд хяналт тавих бөгөөд шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт шалгалт хийлгэж болно.” гэж заасан нь заавал аудитаар хянагдах шаардагатай гэдгийг харуулж байна. Гэхдээ зарим аймгийн Аудитын байгууллагаас тухайн аймгийн Сум хөгжүүлэх сангийн хэрэгжилт, үр ашигт үнэлгээ хийж, гүйцэтгэлийн аудитын тайлан гаргаж байна. Эдгээр аудитын дүгнэлтүүдээс харахад зээлийг зориулалтын дагуу ашиглаагүйн улмаас эргэн төлөх чадваргүй болсон, ЖДҮ –ийг хөгжүүлэх, тэргүүлэх чиглэлд нийцээгүй, төслийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн тооцоогүй зэрэг зөрчлүүд нийтлэг илэрч байна.

Зарим улс орны туршлагаас харвал, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилготой тусгай зориулалттай сангууд, хөнгөлөлттэй бизнесийн зээл тусламжуудын зориулалт, зарцуулалт, үр өгөөж, хэрэгжилтийг гол төлөв өөрийн орны онцлогт нийцүүлэн орон нутгийн хүн амын нягтшил, дэд бүтцийн хөгжил, нөөцийн ашиглалт болоод улс орны хөгжлийн бодлоготойгоо уялдуулан шийдвэрлэж байна. Тухайлбал, Өмнөд Африкийн орнуудад тулгамдаж буй гол асуудлууд нь санхүүжилт авах боломж багатай, тухайн зах зээлдээ нэвтрэх, хууль дүрмийн нарийн тогтолцоо хангалтгүй, мэргэжлийн ур чадвар нь дутмаг зэрэг манайхтай төстэй төлөв байдал ажиглагдаж байжээ. Эдгээр асуудлуудыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэхийн тулд юуны өмнө бүс, орон нутаг тус бүрийн харьцангуй давуу талд тулгуурлан үйлдвэрлэлийг ялгаатай байдлаар хөгжүүлэх, орон нутаг дахь бизнес эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг сайжруулах, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний зах зээлийн сувгуудыг оновчтой шийдвэрлэх зэрэг шат дараатай арга хэмжээ авсан нь үр дүнгээ өгсөн байна.

Дүгнэлт

Энэхүү судалгаагаараа бид Монгол Улсын Засгийн газраас санхүүжүүлж буй сум, орон нутгийн хөгжил, ЖДҮ-ийг дэмжих зориулалт бүхий тусгай зориулалттай сангийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх боломжийг тодорхойлох зорилгын дагуу орон нутгууд дах тусгай зориулалттай сангуудын хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудит тайлангууд, СХС, ОНХС-уудын зээлдэгчдийн мэдээллийг голчлон ашигласан бөгөөд судалгааны эцэст бид дараах нэгдсэн дүгнэлт болон санал зөвлөмжийг боловсруулав. Үүнд:

- Иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд бичсэн төслийн дагуу бүрэн санхүүжилтээ авч чадахгүйгээс болж үйл ажиллагааны зардал ихсэх,

үйл ажиллагаа нь тогтворжиж, өсөж чадахгүй байх зэрэг асуудал гарч байгаа тул зээлийн санхүүжилтийг хийхдээ тухайн төслийг судалж буй тал нарийн тооцоолол хийх;

- Экспортод чиглэсэн, нэмүү өртөг шингэсэн, өрсөлдөх чадвартай, өртөг багатай түүхий эдийн нөөц, боломжид тулгуурласан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бүс, аймаг, сум тус бүрийн харьцангуй давуу талд тулгуурлан дэмжин хөгжүүлэх;
- Сум, орон нутаг дахь сонгон шалгаруулалт явуулах иргэд, эрх бүхий албан тушаалтнуудад тухайн сангийн хөрөнгийн төлөвлөлтийг бодитой, үндэслэл сайтай боловсруулах чадвар эзэмшүүлэх, дадлагажуулж, түүнд хяналт тавих;
- Аймаг, сум бүр цахим хуудастай боловч мэдээлэл, ил тод байдал хангалтгүй байдаг тул ялангуяа ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэлэлцэх баг, хорооны иргэдийн нийтийн хуралд оролцох иргэдийн оролцоог сайжруулж, ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг олон нийтэд цаасан болон цахим хэлбэрээр тогтмол, түргэн шуурхай хүргэдэг болох.


Ашигласан материал

- [1] Ali.I, S. H. (2007). Measuring Inclusive Growth. *Asian Development Review*.
- [2] Alicja.S. (2009). Theories of regional and local development. *Social economic series* .
- [3] Dagsupta.P. (2007). Measuring Sustainable Development: Theory and Application. *Asian Development Review*.
- [4] Enright, J. W. (2000). Local partnetship, Cluster and SME Globalization. *Conference for Minister responsible for SMEs and Industry Minister. Italy*.
- [5] Isard.W, I. (1965). General social, political and economic equilibrium for a system of regions. *Regional Science Association*.
- [6] БХААГ. (2018). *Сум хөгжүүлэх сангийн хэрэгжилт, үр ашгийн үнэлгээ*. Баянхонгор аймаг.
- [7] Лемон, Ж. (2004). “Бүс нутгийн хөгжлийг дэмжих эдийн засгийн бодлогын хүрээ” . *Мон 3948 ТТ*, (р. хэлэлцүүлгийн баримт бичиг 2. “Capacity Building for Integrated Regional Development Planning”). Улаанбааар хот.
- [8] Монгол банк, С. (2016). *Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал*. Улаанбаатар хот: Монгол банк.

- [9] Монголбанк. (2018.10). *Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал*. Улаанбаатар.
- [10] ОААГ. (2018). *Сум хөгжцүүлэх сангийн хэрэгжилт, цр ашгийн үнэлгээ*. Орхон аймаг.
- [11] УИХ. (2015). *Монгол улсын Захиргааны Ерөнхий хууль 9-р бчлэг, 92.1*. Улаанбаатар.
- [12] УИХ. (2018). *Монгол улсын төсвийн тухай хууль, шинэчилсэн найруулга, 58.1.1-58.1.21*. Улаанбаатар.
- [13] ХӨАГ. (2018). *Сум хөгжцүүлэх сангийн хэрэгжилт, цр ашгийн үнэлгээ*. Хөвсгөл аймаг.


Хавсралт

Хавсралт 1. ДНБ, салбараар, бүс нутгаар (сая төгрөг)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, www.1212.mn

Хавсралт 2. Орон нутгийн төсвийн орлого, бүсээр, улсын дүнд эзлэх хувиар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, www.1212.mn

Хавсралт 3. Орон нутгийн төсвийн тэнцэл, бүсээр, улсын дүнд эзлэх дүн (сая төгрөгөөр)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, www.1212.mn